

## **СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Компанийн хэмжээнд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх асуудлаар шийдвэр гаргах, уг хэлцлийн талаар холбогдох этгээдэд мэдээлэл өгөх, хэлцэлд хяналт тавих асуудлыг энэ журмаар зохицуулна.

1.2. Аливаа хэлцлийг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэж үзэх эсэх асуудлаар уг хэлцлийг хийх тухай шийдвэр гаргуулахаар асуудал боловсруулан холбогдох шатны удирдлагад асуудал танилцуулж байгаа эрх бүхий албан тушаалтан саналаа Хуулийн хэлтэст танилцуулах бөгөөд хуулийн хэлтэс хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсхүл их хэмжээний гэж үзэх эсэх тухай дүгнэлт гаргана.

### **Хоёр. Их хэмжээний хэлцэл хийх журам**

2.1. Дараах нөхцөлийг хангаж байгаа хэлцлийг их хэмжээний хэлцэл гэж үзнэ:

2.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

2.1.2. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

2.2. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл дараах журмаар тогтооно.

2.2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн, эсхүл хэд хэдэн гишүүн, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийг тогтоох шаардлагатай хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд зуучилж байгаа, уг хэлцлийн үр дүнд шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд зах зээлийн үнийг уг хэлцлийг байгуулах талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.2.2. Энэ журмын 2.2.1-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд уг хэлцэлд оролцогч, зуучлагч талуудтай нэгдмэл сонирхолгүй, энэ хэлцлийн үр дүнд шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэхгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонирхлын

зөрчилгүй этгээд гэж үзэх бөгөөд ийм сонирхолын зөрчилгүй гишүүд санал хураалтад оролцоно.

2.2.3. Тухайн хэлцлийн талаар сонирхлын зөрчилтэй гишүүн энэ тухайгаа уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хурал даргалагчид мэдэгдэх бөгөөд ямар шалтгааны улмаас уг хэлцэлд сонирхлын зөрчилтэй болох тухайгаа мэдэгдэнэ. ТУЗ-ийн гишүүн хэн хэн, хэлэлцэж буй хэлцлийн талаар сонирхлын зөрчилтэй, сонихлын зөрчлийн шалтгаан юу болох талаар ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд тусгасан байх бөгөөд сонирхлын зөрчил бүхий гишүүд их хэмжээний хэлцлийн зүйлийн үнийг тогтоох санал хураалтад оролцоогүйг тэмдэглэлд тусгасан байна.

2.2.4. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо төлөөлөн удирдах зөвлөл нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

2.2.5. Төлөөлөн удирдах зөвлөл эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно.

2.2.6. Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу буюу хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа компанид эргүүлэн худалдах эрх үүссэн үед уг эрхийг хэрэгжүүлэхээр хувьцааны үнийг тодорхойлж байгаа бол заавал хараат бус үнэлгээний байгууллага, аудитын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхойлно.

2.3. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтэйгээр гаргана. Өөрөөр хэлбэл их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах хуралд ТУЗ-ийн бүх гишүүд оролцсон тохиолдолд хурлыг ирц бүрдсэн гэж үзэх бөгөөд ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтэй зөвшөөрсөн тохиолдолд их хэмжээний хэлцлийг зөвшөөрсөн гэж үзнэ.

2.4. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

2.5. Их хэмжээний хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлсэн тохиолдолд уг асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

2.6. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах, МХБ-ийн цахим хуудсанд болон өөрийн цахим хуудсанд тавих зэргээр нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

### **Гурав. Сонирхлын зөрчил бүхий этгээд**

3.1. Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд гэж үзнэ:

3.1.1.хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

3.1.2.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

3.1.3.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

3.1.4.хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

3.2.Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:

3.2.1.тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;

3.2.2.тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;

3.2.3.тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд.

3.3. Энэ журмын заалтууд дараах тохиолдолд үл хамаарна:

3.3.2.хувьцаа эзэмшигч нь энэ КтХ-ийн 38 дугаар зүйлд заасны дагуу буюу нэмж гаргаж байгаа хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх;

3.3.3.компани нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авах;

3.3.4.бусад компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компани нь КтХ-ийн 20 дугаар зүйлд заасны дагуу нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдах.

### **Дөрөв. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага**

4.1.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл болон аудиторт дараах зүйлийг мэдээлэх үүрэгтэй:

4.1.1.дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;

4.1.2.өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;

4.1.3.компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;

4.1.4.энэ журмын 3.1-д заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.

4.2.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

4.3.Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.

#### **Тав. Сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг хийх журам**

5.1.Энэ журмын 3.1-д заасан этгээдийн компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл гишүүдийн олонхийн саналаар гаргана.

5.2.Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг КтХ-ийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

5.3. Дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:

5.3.1.Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;

5.3.2.компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;

5.3.3.төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүн нь / төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус бүх гишүүн/ хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.

5.4.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

5.5.Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэ журмын 5.3-т заасны дагуу батлуулах шаардлагагүй.

5.6. КтХ-ийн 89 дүгээр зүйлд заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцогдохоос өмнө компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурал болох хүртэл энэ журмын 5.3-т заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагагүй.

5.7.Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх өдөр компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд энэ журмын 5.3-т заасан шаардлагыг хангасанд тооцно..

### **Зургаа .Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөний үр дагавар**

6.1.Энэ журмын 4.1-д заасан этгээд нь энэ журмаар тогтоосон шаардлага, журам зөрчсөний улмаас компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

6.2. Энэ журмын шаардлагазөрчсөн, эсхүл компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг тухайн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

6.3. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч, эсхүл компани нь сонирхлын зөрчил бүхий этгээд эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдээр компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.



